		Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд	Аймгийн хөгжлийн бодлогыг төлөвлөхөд санал авах, хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх
		Сумдын ЗДТГ	Аймгийн хөгжлийн бодлогыг төлөвлөхөд санал авах, хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх
		Аж ахуйн нэгж байгууллага	Хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах Ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх
		Иргэн	Хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах Иргэдийн ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх
22	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх	Сангийн Яам	- Төсвийн төслийн санал, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлэх - Мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангуулах - Холбогдох хууль, журмын төсөлд санал хүргүүлэх
		Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	- Төсвийн төсөл, тодотголын төслийг хэлэлцүүлэх, батлуулах - Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнах
		Сумдын ЗДТГ	- Мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах - Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах
		Төсвийн байгууллага	- Төсвийн байгууллагын орон тоог батлах - Хэрэгжүүлэх хөтөлбөр, хэвийн үйл ажиллагааг хангах санхүүжилтийг бодитой тодорхойлох
		Төрийн аудитын газар	- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, явцад аудит хийлгэх
		Дотоод аудитын хороо	- Харьяа төсвийн байгууллагуудад хийх дотоод хяналтын төлөвлөгөө батлах, гүйцэтгэлийг хянах
23	Татварын хууль, тогтоомж хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэх	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	- Татварын хувь, хэмжээг тогтоолгох - Шийдвэрийн дагуу татварын орлогыг төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах
		ГХБХБГ, УБХ, Цагдаагийн газар, БОАЖГ	- Татварын болон татварын бус орлого төлөвлөхөд хамтарч ажиллах - Орлого бүрдүүлэхэд хамтарч ажиллах
		ААН	- Татварын хувь, хэмжээний дагуу татвар ногдуулах - Татварын хууль, тогтоомжийн талаар сургалт, сурталчилгаа хүргэх
		Иргэд	- Татварын хувь, хэмжээний дагуу татвар ногдуулах - Татварын хууль, тогтоомжийн талаар сургалт, сурталчилгаа хүргэх
24	Статистик, тооллого судалгааг зохион байгуулах, үр дүнг тайлагнах	Статистикийн үндэсний хороо	- Албан ёсны статистикийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангуулах - Удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, судалгааг зохион байгуулах - Статистикийн мэдээллийг хугацаанд хүргүүлэх
		Орон нутгийн бүх шатны төр, төсвийн байгууллагууд	- Статистикийн үйл ажиллагаа явуулахад нь удирдамж, чиглэл өгөх, хяналт тавих - Албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд статистикийн мэдээлэгчээс авах - Статистикийн мэдээллээр үнэ төлбөргүй хангах
		Аж ахуй нэгж байгууллагууд	- Статистик мэдээллийг гаргуулан авах - Мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах

			- Мэдээлэл судалгааны дүнг хүргэх
		Иргэд	- Статистик мэдээллийг гаргуулан авах - Мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах - Мэдээлэл судалгааны дүнг хүргэх
25	Гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;	Гадаад харилцааны яам	Гадаад албан айлчлал хийх, хамтын ажиллагааны баримт бичиг боловсруулах талаар зөвшөөрөл авах, тайлагнах
		Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Гадаад албан айлчлал хийх зөвшөөрөл авах
26	Иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах	Хууль зүй, дотоод хэргийн яам	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах Бодлого арга зүйгээр хангах
		Хууль зүйн үндэсний хүрээлэн	Хууль тогтоомжийн системчлэлийн ажлыг эрхлэн хөтөлж, цаасан болон цахим санг бүрдүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангах
		Иргэд	Хууль зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх
		ААН	Хууль зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх
27	Мэргэжлийн хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах талаар зөвлөгөө дэмжлэг авах, тайлагнах
		Төр, төсвийн байгууллагууд	Хяналтын чиглэлийн харъяалах байгууллагуудад хяналт шалгалт хийх, стандартын шаардлага хангуулах
		Иргэд, аж ахуйн нэгж	Үйл ажиллагаа явуулах зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хяналт шалгалт хийх, зөрчил дутагдлыг арилгуулах, стандартын шаардлага хангуулах
28	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх	Мэргэжлийн хяналтын газар	Хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах талаар зөвлөгөө дэмжлэг авах, тайлагнах
		Гаалийн газар	Хилээр нэвтрэх зорчигчид, тээврийн хэрэгсэлд хийх хяналт, шалгалтыг хамтран зохион байгуулах
		Хилийн анги	Хилээр нэвтрэх зорчигчид, тээврийн хэрэгсэлд хийх хяналт, шалгалтыг хамтран зохион байгуулах
		Хууль хяналтын байгууллагууд	Зөрчил дутагдлыг арилгуулах талаар хамтарч ажиллах
		Иргэд, аж ахуйн нэгж	Хилээр зорчих иргэд, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх, зөрчил дутагдлыг арилгуулах, стандартын шаардлага хангуулах
29	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Стандарт хэмжил зүйн газар	Мэргэшил арга зүйн зөвлөгөө дэмжлэг авах, тайлагнах
		Төр, төсвийн байгууллагууд	Холбогдох стандартаар үйлчлэх, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх
		Иргэд, аж ахуйн нэгжүүд	Стандартаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, тохирлын үнэлгээ хийх, хэмжилзүйн баталгаажилт хийж гэрчилгээ олгох
30	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	Онцгой байдлын ерөнхий газар	Мэргэшил арга зүйн зөвлөгөө дэмжлэг авах, тайлагнах
		Сумдын Засаг дарга	Орон нутагт гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөмж чиглэл өгөх, хяналт тавих
		Хууль хяналтын байгууллагууд	Хяналт шалгалт хамтран зохион байгуулах
		Иргэд, аж ахуйн нэгжүүд	Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, сурталчлах, хамгаалах

31	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах	Батлан хамгаалах яам	Батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд захиргааны удирдлагаар хангах,
		Зэвсэгт хүчний Жанжин штаб	Батлан хамгаалах багц хуулийг хэрэгжүүлэхэд цэргийн мэргэжлийн удирдлагаар хангах
		Сумдын Засаг дарга нар	Хуулинд заасан чиг үүргийг хэрэгжүүлж иргэнд Батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэх, шаардлагатай мэдээ, тайлан гаргах
		Аж ахуйн нэгж байгууллага	Батлан хамгаалахын багц хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж дайчилгааны даалгаврын дагуу эд хөрөнгийг татан нийлүүлэх бэлтгэлийг хангах, бусад үйл ажиллагаанд оролцох, дэмжлэг үзүүлэх
		Иргэд	Хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлэх, энэ хүрээнд санал, гомдлоо хуулийн хүрээнд хариуцсан албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлэх

Алхам 3. Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох.

Аймгийн чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлохдоо Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон холбогдогч талуудын үнэлгээний үр дүнд үндэслэсэн. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Аймгийн чиг үүргийн хэрэгжилт, хувиар

д/д	Чиг үүрэг	Чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ			
		Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайлан (хувиар)	Холбогдогч талуудын үнэлгээ (хувиар)	Дундаж үнэлгээ (хувиар)	
1	Ерөнхий чиг үүрэг 1. Хүн амд нийгэм, соёлын болон нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх (1.1-1.7)	89.4	91.3	90.3	
Үндсэн чиг үүрэг	1.1	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах	90	78.5	84.2
	1.2	Хүн амд боловсролын үйлчилгээг үзүүлэх	88.8	89.9	89.3
	1.3	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх	90	92	91
	1.4	Соёл урлагийг хөгжүүлэх	73	89.9	81.4
	1.5	Нутаг дэвсгэрийн хүн амын нийгмийн хамгаалал, халамжийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх	85	89	87
	1.6	Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих	99.8	100	99.9
	1.7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	99.8	100	99.9
2	Ерөнхий чиг үүрэг 2. Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах (2.1-2.3)	100	74.1	87.0	
Үндсэн чиг үүрэг	2.1	Нутаг дэвсгэрийн байгалийн баялгийг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх	100	75.4	87.7
	2.2	Газар, газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангах	100	71.7	85.8
	2.3	Ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих	100	75.4	87.7
3	Ерөнхий чиг үүрэг 3. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх (3.1-3.4)	88.3	100	94.1	

Үндсэн чиг үүрэг	3.1	Нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх	96.2	100	98.1
	3.2	Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	80	100	90
	3.3	Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	88.7	100	94.4
	3.4	Орон нутгийн чанартай зам гүүр, харилцаа холбоог хөгжүүлэх	-	-	-
4	Ерөнхий чиг үүрэг 4. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх	100	100	100	
Үндсэн чиг үүрэг	4.1	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах, бодлого, шийдвэр хэрэгжүүлэх	100	100	100
5	Ерөнхий чиг үүрэг 5. Хүнсний аюулгүй байдлыг хангаж, ХАА-ыг хөгжүүлэх (5.1-5.5)	95	95.3	95.2	
Үндсэн чиг үүрэг	5.1	Газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	97.2	96.1	96.6
	5.2	Мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	97.2	95.1	96.1
	5.3	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний бодлого хэрэгжүүлэх	90.6	95.5	93.0
	5.4	Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс тэжээлийн нөөцийн талаарх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	90.0	90.0	90.3
	5.5	Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	100	100	100
6	Ерөнхий чиг үүрэг 6. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв санхүү, статистикийн бодлого хэрэгжүүлэх (6.1-6.4)	98.7	97.2	98	
Үндсэн чиг үүрэг	6.1	21.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагаар хангах	100	100	100
	6.2	Орон нутгийн төсөв, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх	95	95	95
	6.3	Татварын хууль, тогтоомж хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэх	100	100	100
	6.4	Статистик, тооллого судалгааг зохион байгуулах, үр дүнг тайлагнах	100	94	97
7	Ерөнхий чиг үүрэг 7. Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдлыг хангах (7.1-7.7)	99.1	91.5	94.6	
Үндсэн чиг үүрэг	7.1	Гадаадад тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх;	100	76.4	88.2
	7.2	Иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөөг хамгаалах	94.7	93.6	94.1
	7.3	Мэргэжлийн хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх	100	91.4	95.7
	7.4	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх	-	90.5	90.5
	7.5	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	100	100	100

7.6	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	100	92.5	96.2
7.7	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах	100	96.2	98.1
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ (1+2+3+4+5+6+7)		95.7	92.7	94.1

Жич: Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний хувиар тооцлоо. Холбогдогч талын үнэлгээг салбарын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтийн 2016-2020 оны үнэлгээний дундаж хувиар тооцсон болно.

ГУРАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний үндсэн зорилго нь аймгийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход чиглэсэн. Аймгийн орчны шинжилгээг хийхдээ PESTLE аргын дагуу үзүүлэлт тус бүрээр нөхцөл байдлыг тодорхойлж, үр дүнг дараах CBOT хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 5. Аймгийн орчны шинжилгээний үр дүн (CBOT)

	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Аймгийн газар нутаг, байршил	<ul style="list-style-type: none"> • Нийслэл Улаанбаатар хотоос харьцангуй ойр, 320 км-т оршдог. Улаанбаатар хоттой авто болон төмөр замаар холбогдсон • Нийслэлийн дараа орох хоёр том хоттой буюу хоёр том зах зээлд ойр байршилтай- (Дархан-100 км, Эрдэнэт-280 км) • Аймаг нь Хэнтий, Төв, Орхон, Булган аймгуудтай хил залгаа бөгөөд газар зүйн хувьд ОХУ-тай хил залган оршдог онцлогтой. ОХУ-тай хил залгаа, Алтанбулаг боомттой нь гадаад худалдааны таатай нөхцөл болдог • Аймаг нь дэд бүтэц, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл сайн хөгжсөн, байгалийн дагалт баялаг ихтэй • Орхон Сэлэнгийн сав газар байршилтай нь газар тариалан эрхлэхэд таатай • Байгалийн нөөц, ашигт малтмал элбэг нь уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөл болдог - Аймгийн нутгийн баруун хойд хэсгээр юрийн хурдас, өмнөд хэсгээр нь герциний боржин, зүүн хэсэгт гүний боржин тархсан, Улаантолгой, Шарын голын нүүрс, Төмөртэй, Төмөртолгойн төмөр, Их алтат, Буганг, Толгойтын алт болон барилгын материалын нөөц элбэг. • Байгалийн үзэсгэлэнт газар олонтой, аялал жуулчлал хөгжихөд тааламжтай 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн баялагийн ашиглалт, газар тариалангийн болон уул уурхайн үйлдвэрлэлтэй уялдсан нөхөн сэргээлтийн асуудал тулгамдсан. Нөхөн сэргээлт хийгдээгүй, эвдэрсэн газар ихтэй • Аймгийн төв дунд Дархан-Уул аймаг оршдог тул, эдийн засаг, худалдааны зах зээл Дархан-Уул аймаг руу чиглэсэн. • Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас олон булаг, шанд ширгэсэн
Хүн амын нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> • Аймгийн хүн ам өссөн • Аймгийн хүн ам насны бүтцийн хувьд залуужиж байна • Хүн амын дундаж наслалт улсын дунджаас өндөр • Хүн амын шилжин ирэгчдийн тоо нэмэгдэж байна. • Хүн амын аймгийн төв рүү болон нийслэл рүү шилжих шилжилт хөдөлгөөн харьцангуй бага бөгөөд энэ үзүүлэлтээр аймгуудын дунд эхний дөрөвт эрэмбэлэгддэг 	<ul style="list-style-type: none"> • Хүн амын насны бүтцийн хандлагаар аймгуудын дунд 15-18 дугаарт эрэмбэлэгддэг • Аймгийн өрхийн тоо буурч байгаа • Гэр бүлийн өнөөгийн байдал, амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт хандлагыг дагаж, гэр бүл салалт, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байна • Гэр бүлийн халуун дулаан орчинд өсөж торних боломжгүй хүүхдийн тоо нэмэгдсээр байна
Засаглалын нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> • Бодлогын залгамж чанар сайн байдаг • Хүний хөгжлийн үзүүлэлтээр 5-6 дугаарт эрэмбэлэгддэг. • Аймгийн өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ сүүлийн найман жилийн 	<ul style="list-style-type: none"> • Хэдийгээр аймаг өрсөлдөх чадвараараа топ 10-т багтан эрэмбэлэгддэг нь боломжийн сайн үзүүлэлт хэдий ч сүүлийн найман жилд эрэмбэ тасралтгүй буурч байна. 2020 оны

	<p>хугацаанд нилээд хэлбэлзлэлтэй байгаа боловч ерөнхий динамик удаан боловч өсөх хандлагатай байна. Өрсөлдөх чадвараараа топ 10 аймагт багтдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн шударга байдлын үнэлгээ сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. • Сэлэнгэ аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч байна. • Хэдийгээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь иргэдийн үнэлгээ 50 хүртэлх хувьтай байдаг ч бусад аймгуудтай харьцуулахад эхний зургаад эрэмбэлэгддэг. • Нэг цонхны үйлчилгээний төвөөр үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн • Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэдэг болсон • Сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тоо буурч байна • Аймгийн хэмжээнд удирдах албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэл сайн байна. • Аймгийн төрийн албан хаагчдын боловсролын түвшин сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. • Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдад зэрэг дэв олгосон байдлыг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл ерөнхий төлөв өсөлттэй байна. • Төрийн албан хаагчдад зориулсан сургалт, хөгжлийн ажил эрчимтэй хийгдэж байгаа • Төрийн албан хаагчдын талаарх иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын тоо буурч байна • Аймгийн гадаад харилцаа сүүлийн жилүүдэд өргөжих хандлагатай, тэр дотроо аймгийн эдийн засгийн гол тулгуур болсон хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр түлхүү хөгжиж байна. • 2017 онд “Аймгийн гадаад харилцааг эдийн засагжуулах” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж хоёр жил тутам үр дүнг тооцон ажиллаж байгаа нь гадаад харилцааны үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болсон байна. 	<p>байдлаар аймаг өрсөлдөх чадвараараа 9-рт эрэмбэлэгдсэн нь сүүлийн найман жилийн түүхэн дэх хамгийн хойгуур эрэмбэ бөгөөд 2012 оны эрэмбэтэй харьцуулахад дөрвөн байраар ухарсан байна</p> <ul style="list-style-type: none"> • Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд аймгийн хэмжээнд боловсруулж гаргасан бодлого, шийдвэрийн оновчтой байдлын үнэлгээ нь буурсан үзүүлэлттэй байна. • Төрийн байгууллагуудын үйл ажиллагаан дахь иргэдийн үнэлгээ тааруу -5 хүртэл оноо (10 онооноос) (ил тод байдал, үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй байдал, авлигын нөхцөл байдал, аймгийн удирдлагын шийдвэр, бизнес эрхлэлтийн дэмжих гэх мэт) • Аймгийн хүний хөгжлийн үзүүлэлтийн ерөнхий төлөв буурсан • Орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо сул, тэдний эрх зүйн боловсрол дутмаг байна • ИТХ-д сонгогдсон төлөөлөгч иргэдтэйгээ эргэх холбоо сул байдаг • Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна. • Гадаад харилцаа нь илүү зээл, тусламж авах, туршлага судлахад илүү чиглэгдэж байгааг ахисан түвшинд гаргахад чиглэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.
Эдийн засаг, бизнес	<ul style="list-style-type: none"> • ДНБ-ний хэмжээгээр аймгуудаас гуравдугаарт ордог • Аймгийн иргэдийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа • Аж үйлдвэр, барилгын салбарын борлуулалт болон энэ салбарын хөгжлөөр улсад 3-5 дугаар байрт эрэмбэлэгддэг • Монгол улсын газар тариалангийн гол бүс нутаг 	<ul style="list-style-type: none"> • ДНБ-д эзлэх төсвийн орлогын үзүүлэлтээр аймгуудын дунд 18-19-т эрэмбэлэгддэг. • Аж үйлдвэрийн салбар уул уурхайгаас хэт хамааралтай байна. • Газар тариалангийн салбарын түр ажлын байранд(хавар, намар) ажиллах хүчин дутмаг • Газар тариаланг дэмжих тээвэр ложистикийн хөгжил сул

	<ul style="list-style-type: none"> ○ Тариалсан талбайн хэмжээгээр улсад нэгдүгээрт ○ Улсын хэмжээний үр тарианы 50-60 хувь, төмс хүнсний ногооны 25-30 хувийг үйлдвэрлэдэг • Эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх бааз суурь сайтай • Алтанбулагийн чөлөөт бүсээр дамжин гадаад худалдааны эргэлт болон зорчих хөдөлгөөний урсгал ихтэй • Байгалийн баялагийн нөөц ихтэй (ус, ой мод, хөрс, ургамал, элс, жимс жимсгэнэ гэх зэрэг байгалийн дагалдах баялаг) бөгөөд түүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн • Уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөн • Байгалийн үзэсгэлэнт газар болон газар тариалан, эрчимжсэн мал ахуйн үйлдвэрлэлд түшиглэсэн аялал жуулчлал хөгжих таатай нөхцөлтэй • Том зах зээлүүдэд ойр байрлалтай нь бүтээгдэхүүний борлуулалтад эерэг нөлөөтэй • Бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийн тоогоор аймгууд дундаа 2-3 дугаарт эрэмбэлэгддэг • Томоохон аж ахуйн нэгжийн тоогоор улсад 6 дугаарт эрэмбэлэгддэг • Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч байна. • Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, уул уурхай, үйлдвэр, худалдааны салбарт шинээр ажлын байр бий болж байна • 2010 оноос хойш үйлчилгээний салбар тасралтгүй өсөлттэй. Аймгийн худалдаа үйлчилгээний салбарын цахим худалдан авалт нийт борлуулалтын 30 хувийг эзэлж нэмэгдэх хандлагатай байна. • Боловсруулах үйлдвэр сүүлийн 10 жилд тогтвортой өсөлттэй байгаа. • Аймгийн хэмжээнд тусгай хэрэгцээнд авах газар нутгийн бодлогыг хэрэгжүүлснээр байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжлийн ач холбогдол, аялал жуулчлал хөгжүүлэх, ашигт малтмалын илэрцүүдийг хадгалан үлдэж чадсан. • Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо тасралтгүй өсч байгаа нь аймгийн эдийн засагт эерэг нөлөөг үзүүлж байна. • Нийт аж ахуйн нэгжийн 60 орчим хувь нь худалдаа үйлчилгээ үйлчилгээ, хөдөө аж ахуй, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь аймгийн эдийн засагт гол байр суурийг эзэлж байна. 	<ul style="list-style-type: none"> • Тариалангийн эргэлтийн нийт талбайн 48,8 орчим хувь нь хүчтэй элэгдсэн, хөрсний ялзмаг 40 шахам хувиар буурсан. • Мал аж ахуй, газар тариалангийн хоршилт хөгжөөгүй. • Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулалт, хэрэгжилт хангалтгүй. • Сумдад ахуй үйлчилгээний нийлүүлэлт доголдолтой. • Хөдөлмөрийн зах зээл сул хөгжсөн, иргэдийн ажил хийх хүсэл сонирхол буурсан, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсан. • Бизнес эрхлэгчдийн судалгаагаар мэргэшсэн ажиллах хүчнийг олж ажиллуулахад төвөгтэй гэж тодорхойлогдсон бөгөөд аймгуудын дунд энэ үзүүлэлтээр 13-15-рт эрэмбэлэгддэг. • Мэргэшсэн ажиллах хүчний шилжих хөдөлгөөн их байгаа нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна. Нийт аймгуудын дунд энэ үзүүлэлтээр 15-16 дугаарт эрэмбэлэгддэг • Аймгийн хэмжээнд боловсролтой ажилгүй иргэдийн тоо их байна • Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, зардал өссөн дүнтэй байна • Аймгийн хэмжээнд 2017 оноос хойш нийгмийн даатгалд хамрагдалтын хувь буурч байна. • Зэрлэг амьтны тархац нутагт амралт, жуулчны бааз байгуулж байгаа нь орчны бохирдол үүсгэж, хөрс бохирдуулах, дуу чимээ, үнэр зэргээс шалтгаалан зэрлэг амьтад бүс нутгаас дайжих нөхцөл бүрдсэн. • Уул уурхайн хайгуул, ашиглалтаас болж эвдэрсэн 1721 га талбай нөхөн сэргээлт хийгдээгүй байна. • Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй. • Үйлдвэрүүдийн зах зээлд өрсөлдөх чадвар муу • Эрдэс баялгийн нөөцийн (ашигт малтмалын) ашиглалт ба зохицуулалт муу (Гар аргаар алт олборлогчид, нинжа нар ихтэй) • Бэлчээрийн даац хэтэрсэн, доройтол ихтэй сумд цөөнгүй байгаа • Хадгаламж эзэмшигчдийн нийт хүн амд эзлэх хувиар аймгууд дунд 13-14 дүгээрт эрэмбэлэгддэг • ДНБ-д эзлэх хадгаламжийн үлдэгдлийн хувиар аймгууд дунд 17-20 дугаарт эрэмбэлэгддэг
--	---	--

	<ul style="list-style-type: none"> • Сүхбаатар, Алтанбулаг боомтоор орох, гарах зорчигчдын ачаа тээврийн эргэлт сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. • Сүхбаатар, Алтанбулаг боомт, Алтанбулагийн чөлөөт бүсэд хийгдэж буй гадаад худалдааны нийт эргэлт сүүлийн 8 жилийн байдлаар өсөх хандлагатай байна. • Гадаад худалдааны нийт эргэлтийн 98-99 хувь нь Сүхбаатар, Алтанбулаг боомтоор хийгдэж байна. 	<ul style="list-style-type: none"> • Чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувиар аймгууд дунд 17-20 дугаарт эрэмбэлэгддэг. • Төр, хувийн хэвшлийн түншлэл аймагт хангалтай хэрэгждэггүй гэж иргэд үзэж байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр аймгууд дунд 15-17 дугаарт эрэмбэлэгддэг • Хэдийгээр аймаг ХАА-н тэр дотроо эрчимжсэн аж ахуй, газар тариалангийн гол бүс хэрнээ аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн дотор хөдөө аж ахуйн чиглэлийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь аажмаар буурч байна. • Аймаг нь томоохон хотуудад ойр байрлалтай, өрсөлдөх чадвар сул байгаа нь жижиг, дунд үйлдвэрлэл, тэр дотроо хүнсний үйлдвэрлэл хөгжихөд сөргөөр нөлөөлж зөвхөн түүхий эд нийлүүлэгчийн байр суурьтай байхад хүргэж байна. • Сүхбаатар, Алтанбулаг боомт, Алтанбулагийн чөлөөт бүсэд хийгдэж буй гадаад худалдааны нийт эргэлтийн 97-98 хувийг импорт эзэлж байна. • Алтанбулагийн чөлөөт бүсэд хийгдэж буй худалдаа нийт гадаад худалдааны эргэлтийн нэг хүрэхгүй хувийг эзэлж байгаа бөгөөд бүсэд үйл ажиллагаа эрхлэхээр бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 60 орчим хувь нь үйл ажиллагаа явуулаагүй, 26% нь барилга байгууламж барьсан, зөвхөн 13.9 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Гэвч эдгээр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь импортын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний худалдаанаас хэтрэхгүй байна.
Дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> • Улсын хэмжээний төмөр зам ба авто замын гол зангилаа нутаг бөгөөд хилийн байнгын ажиллагаатай чухал гарцын нэг, • Аймгийн 17 сумын 70 гаруй хувь нь буюу 12 сум нь хатуу хучилттай замаар холбогдсон. Аймгийн хэмжээнд 2019 оноос шинээр ашиглалтад оруулсан хатуу хучилттай зам нэмэгдсэн. • Аймгийн хэмжээнд эрчим хүчний болон усан хангамжийн үйлдвэрлэлт, борлуулалт жилээс жилд өсөн нэмэгдэж байна. • Аймгийн хэмжээнд цахилгаан, эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо сүүлийн 10 жилийн динамик үзүүлэлтээр өссөн дүнтэй байна. • 2020 оны байдлаар халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 18.5 байгаа нь 2010 оноос 2.1 пунктээр өссөн. • Уст цэгийн хүртээмж сайн. • Аймгийн 16 сум “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК, 	<ul style="list-style-type: none"> • Аймгийн хэмжээнд хатуу хучилттай замын чанарт өгсөн иргэдийн үнэлгээг сүүлийн 8 жилээр авч үзвэл ерөнхий төлөв нь бууралттай байна • Тээврийн салбарын нийт орлого 2019 онд 1 117.7 сая төгрөгт хүрч өмнөх оноос 38.3 хувиар буурсан байна. • Сумдын 20 гаруй хувь нь хатуу хучилттай замгүй.

	<p>Баруунбүрэн сум “Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-иас цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн хэмжээнд цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоог 10 жилийн динамик үзүүлэлтээр харьцуулан үзвэл 2020 онд 24601 өрх төвлөрсөн системд холбогдож 2010 оноос 8.5 хувь буюу 2107 өрхөөр нэмэгдсэн байна. • Цахилгаан үүсгүүртэй малчин өрхийн тоогоор аймгуудын дунд 2-3-рт эрэмбэлэгддэг. Хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, жижиг оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байгаа өрхийн тоо нэмэгдэж байна. • Аймгийн хэмжээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтцийн хөгжил сайн байна. Энэ нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтцийн давуу талыг ашиглан бизнес хийж, үйлчилгээ үзүүлж, хөдөлмөрийг хөнгөвчилсөнөөр бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад нөлөөлж байна. • Аймгийн хэмжээнд суурин утасны цэг, үүрэн утасны идэвхтэй хэрэглэгч, кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд өсөлттэй байна. Сүүлийн жилүүдэд гар утас, интернетийн хэрэглээ нэмэгдэж байна. 	
<p>Нийгэм, соёлын нөхцөл байдал</p>	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц хөгжлөөр аймгуудын дунд 3-рт эрэмбэлэгддэг • Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн байгууллагуудын дэд бүтцийг сайжруулах хүрээнд барилгын их болон урсгал засварууд, багийн бага эмчийг мотоцикл, гэрээр хангах, түргэн тусламжийн машинуудын парк шинэчлэлтийг сайжруулах, шилэн кабельд холбох зэрэг ажлуудыг үе шаттайгаар хийж байна. • Аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл буурч байгаа бөгөөд эхийн эндэгдэл болон нас баралтын ерөнхий коэффициентын үзүүлэлтээр аймгуудын дунд эхний гуравт эрэмбэлэгддэг. • Сүүлийн жилүүдэд нялхсын эндэгдэл буурч байна • Сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр аймгийн хэмжээнд их эмчийн тоо өссөн. • СӨБ-ын байгууллагын тоо, сурагч багшийн харьцааны үзүүлэлт зэргээр аймгуудын дунд эхний гуравт эрэмбэлэгддэг • СӨБ-ийн байгууллагын багшийн тоо өсч байна. Энэ нь нэг багшид ногдох хүүхдийн тоо буурч, багш хүүхэдтэйгээ 	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, жирэмсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн хяналтад хамрагдалт, төрөлтийн ерөнхий коэффициентийн үзүүлэлтээр аймгуудын дунд 18-19-рт эрэмбэлэгддэг. • Аймгийн хэмжээнд төрөлт буурсан нь хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. • Аймгийн хэмжээнд нас баралт улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. • Аймгийн хэмжээнд халдварт бус өвчний тохиолдол жилээс жилд нэмэгдэж байна. • Хүн амын дунд таргалалт, зүй бус хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ, стресс, орчны бохирдол зэрэг эрсдэлт хүчин зүйлийн тархалт их байгаа нь артерийн даралт ихсэх, зүрхний шигдээс, тархины цус харвалтын тохиолдол болон тэдгээрийн хүндрэлд хүргэж байна. Аймгийн нийт хүн амын дунд нас баралт их байна. Үүний шалтгаан нь зүрх судасны тогтолцооны өвчин (48.9 хувь) болон хавдрын өвчин (20.3 хувь) байна. • Аймгийн хэмжээнд нэг хүртлэх насны хүүхдийн эндэгдэл их байна. Үүний

	<p>хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Сүүлийн жилүүдэд сургуульд хамрагдалтын хувь нэмэгдэж байгаагийн зэрэгцээ аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо өссөн дүнтэй байна. • Аймгийн хэмжээнд сурагчдын сурлагын чанар суурь болон дунд боловсролын хувьд сайжирч байна. • Мэргэжлийн урлагийн тоглолт, үзэгчийн тоогоор аймгуудын дунд 1-4 дүгээр байрт эрэмбэлэгддэг. • Аймгийн хэмжээд иргэдийнхээ эрүүл мэнд, амьдралын зөв хэв маяг дэмжих зорилгоор биеийн тамир спортын үйл ажиллагаанд анхаарал хандуулан тус салбарын хүний нөөцийг чадавхжуулах, барилга байгууламжийг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хийж байна. • Сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээнд спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэж байна. • Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын тоо өссөлттэй байна • Аймгийн хэмжээнд улс, бүсийн чанартай тэмцээн, уралдааныг хүлээн авч зохион байгуулах үйл ажиллагаа тогтмолжиж, сүүлийн жилүүдэд эрчимжиж байна. 	<p>шалтгааны нь ихэнх хувийг амьсгалын замын өвчин (41,7 хувь) эзэлж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн хэмжээнд 1-5 насны хүүхдийн эндэгдэл их байна. Үүний хамгийн гол шалтгаан нь зам тээврийн осол (71,0 хувь) байна. • Аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд халдварт өвчний тохиолдол ихсэж байна. Нийт халдварт өвчний 56.6 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 22.6 хувийг сүрьеэ, 20.8 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна. • Бага, дунд, суурь боловсролын хамран сургалтын үзүүлэлтээр 21 аймгаас хойноосоо 2-рт (19-рт) эрэмбэлэгдэж байна. • Хот, хөдөөгийн хүн амын боловсролын түвшин ялгаатай байна. • Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоогоор 18-21-рт эрэмбэлэгддэг • Биеийн тамир, спортын салбарын цолтой тамирчид, дасгалжуулагчдын тоо сүүлийн жилүүдэд буурч байна. • Гэмт хэргийн гаралтын үзүүлэлтээр 17-18 дугаарт эрэмбэлэгддэг • Аймгийн хэмжээнд иргэдийн хөл хөдөлгөөн тасардаггүй, үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг, зөрчлийн гаралт ихтэй байдаг • Аймгийн хэмжээнд гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг нөхөн барагдуулах, эргэн төлүүлэх үйл ажиллагаа сул байна • Аймгийн хэмжээнд ажиллаж байсан 29 ширхэг камер гэмтэж, засварлах, дахин ашиглах боломжгүй болсон
	БОЛОМЖ	АЮУЛ
Эдийн засгийн нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> • Цар тахалтай холбоотой импортын хүнсний ногооны нийлүүлэлт багасан нь Сэлэнгэ аймгийн хүнсний ногооны борлуулалтыг нэмэгдүүлэх боломж бий болгож байна. • Ази Европыг холбосон олон улсын төмөр зам, хатуу хучилттай авто зам аймгийн нутаг дэвсгэрийн төв хэсгээр дайран өнгөрдөг • Холбоо мэдээллийн дэвшилтэт технологи нэвтэрсэн, дэд бүтцийн хөгжил сайтай, цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон • Монгол Улсын иргэд ОХУ-д визгүй зорчихоос гадна Алтанбулаг-Хиагтын боомт нь хорин дөрвөн цагийн үйл ажиллагаатай болсон нь дотоод, гадаадын жуулчид, иргэдийн урсгал хөдөлгөөн нэмэгдэж байна • Алтанбулагийг чөлөөт бүс байнгын ажиллагаатай болсон нь бүс дэх болон 	<ul style="list-style-type: none"> • Түүхий эдийн үнийн савалгаа аймгийн эдийн засгийн өсөлтийг тогтворгүй болгох эрсдэлтэй. • Төсвийн орлогын хуваарилах зарчим өөрчлөгдөхгүй бол аймаг татаас авдаг байдал үргэлжлэх нөхцөл байдалтай байна. • Орон нутгийн онцлогт тохирсон банк санхүүгийн дэмжлэг байхгүй. • Хөрсний бохирдол, тэр дотроо хүнд металлын бохирдолтой талбайн хэмжээ буурахгүй байна. • Газар тариаланд ашиглаж байгаа 315279.45 га талбайн байгалийн ургамлын төрөл зүйл устгах юмуу дарагдаж хөл газрын ургамлын зүйлээр солигдсон байна. • Сумдын бэлчээрийн ургамалжсан талбайн 44.83% нь дундаас хүчтэй талхагдалд орсон.

	<p>бүс орчмын нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Иймээс чөлөөт худалдааны бүс дэх болон бүс орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой холбон давуу тал болгон ашиглах хэрэгцээ байна.</p>	
Улс төр, хууль эрх зүй	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын тухай хуулиар ерөнхий сайдын эрх хэмжээг нэмэгдүүлсэн нь засгийн газрын тогтвортой байдал нэмэгдсэн. • УИХ-ын олонхын бүлэг тогтвортой үйл ажиллагааг хангах бүрэлдэхүүнтэй байгаа • Хөгжлийн бодлогын эрх зүйн орчин 2020 онд шинэчилсэн тул дахин өөрчлөлт хийхгүй байх магадлалтай. 	<ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хуулийн 58 -р зүйлийн зарим зардлыг Сангийн яам хянаж олгодоггүй нь хөрөнгийн доройтол, ашиглалтын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. • Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг бүрэн боловсруулагдаж дуусаагүй байгаа нь аймгийн стратегийн төлөвлөгөөтэй зөрчилдөж магадлалтай. • УИХ, ИТХ-ын сонгуулийн үр дүнгээс хамааран стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүй орхиж болно. • Урт хугацааны хөгжлийн бодлогыг 7 зорилтот хөтөлбөр, төсвийн хуулийн хөтөлбөр зохицуулалт хоорондын зөрчил стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр хомсдолтой болох магадлалтай
Нийгэм соёл	<ul style="list-style-type: none"> • 	<ul style="list-style-type: none"> • Ковид цар тахлын нөхцөл байдал тодорхойгүй байгаа нь стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд давагдашгүй хүчин зүйл үүсгэж болно. • Иргэдийн санал санаачилга сул идэвхгүй байдлаас хамааран төр иргэний хамтын ажиллагааг зохицуулахад бэрхшээл үүсэх магадлалтай.

ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА

Алсын хараа нь аймгийн ирээдүйн хөгжлийн төлвийг тодорхойлсон үр дүн юм. Сэлэнгэ аймгийн алсын харааг тодорхойлохдоо аймгийн ирээдүйн талаарх төсөөлөл юу вэ?, Ирээдүй хойч үедээ юуг өвлүүлж үлдээх вэ?, Хүмүүсийн амьдралыг хэрхэн сайжруулах вэ? гэсэн гурван асуултыг чиг баримжаа болгосон.



Алсын хараа

Эрчимжсэн хөдөө аж ахуйд суурилсан, байгальд ээлтэй үйлдвэрлэгч аймаг болно.

Уриа

Бүтээлч оролцоо – Хөгжлийн тулгуур

ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрхэм зорилго нь аймгийн одоо ба ирээдүйн хөгжлийн үзэл баримтлал, үнэт зүйл, оршин тогтнох учир шалтгааныг илэрхийлнэ. Сэлэнгэ аймгийн эрхэм зорилгыг тодорхойлохдоо бид юу хийдэг вэ? Хэнд зориулж үүнийг хийдэг вэ?, Яагаад үүнийг хийдэг вэ? гэсэн гурван асуултыг чиг баримжаа болгов.



Эрхэм зорилго

Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэн эдийн засгаа тэтгэж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах

Үнэт зүйл

- *Хууль дээдлэх* – Үйл ажиллагаандаа хуулийг чанд сахин биелүүлэх, хуульд нийцсэн шийдвэр гаргах;
- *Ёс зүй, хариуцлагатай байх* – Ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нөлөөнд автахгүй байх, хариуцсан ажилдаа эзэн байх, тэгш шударга байх;
- *Ил тод байх* – Мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, тэгш хүртээмжтэй байх;
- *Мэдлэг, инновацийг эрхэмлэх* – Шинжлэх ухаанч, шинэ санаа, байгаль орчинд ээлтэй технологид тулгуурласан байх;
- *Мэргэшсэн байх* - Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд чадмаг, сурамгай, найдвартай гүйцэтгэх;
- *Бүтээлч оролцоо, хамтын ажиллагааг хангах* - Бүтээлч хөдөлмөр, идэвхи санаачилгыг өрнүүлэх, төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог аймгийн хөгжилд чиглүүлэх;

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Сэлэнгэ аймгийн орчны шинжилгээний үр дүнг аймгийн цаашдын хөгжлийн стратегийг тодорхойлох үндэслэл болгов. Аймгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

Стратегийн зорилго 1

Ковидоос шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг давна.

Стратегийн зорилго 2

Байгаль орчны эмзэг байдлын индексийг зорилтот түвшинд хүргэнэ.

Стратегийн зорилго 3

1 хүнд ногдох ДНБ-ийг суурь түвшнээс 3 хувиар өсгөнө.

Стратегийн зорилго 4

Хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.704-д хүргэнэ.

Стратегийн зорилго 5

Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө.

Стратегийн зорилго 6

Иргэдийн амар тайван, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдэлийг бууруулна.

**ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
СУУРЬ ТҮВШИН, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Сэлэнгэ аймгийн стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй хэлбэрээр харуулав. Мөн стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаас үзнэ үү.

Хүснэгт 6. Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин

Стратегийн зорилго, зорилт		Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот он	Зорилтот түвшин	Стратеги
1	Ковидоос шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг давах	Сэргэлтийн индекс (1.1*0.33+1.2*0.33+1.3*0.34)/100	оноо	2020	*	2025	0.94	Зорилтот бүлгийн шаардлагад нийцсэн дэмжлэг үзүүлэх
	1.1 Ковидын улмаас ААН-д учирсан доголдлыг бүрэн арилгана	Ковидоос шалтгаалж үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжийн нийт тоонд үйл ажиллагаагаа сэргээсэн ААН-ийн эзлэх хувь	хувь	2020	*	2025	85	-
	1.2 ЕБС-ийн сурагчдын хичээлийн хоцрогдлыг 100 хувь арилгана.	Нийт хоцрогдолтой сурагчдад хичээлийн хоцрогдлыг арилгах хөтөлбөрт хамрагдсан сурагчдын хувь	хувь	2020	*	2023	100	-
	1.3 Ковидоор өвчилсөн иргэдийг бүрэн эмчилнэ.	Ковидоор өвчилсөн иргэдийн эдгэрэлтийн хувь	хувь	2021	92	2025	97	-
2	Байгаль орчны эмзэг байдлын индексийг зорилтот түвшинд хүргэнэ.	Байгаль орчны эмзэг байдлын индекс	индекс	2022	a*	2025	a+0.5	Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангасан зохистой хэрэглээг дэмжих
	2.1 Техникийн нөхөн сэргээлтийг 450 га-аар нэмэгдүүлнэ.	Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ	га	2020	111	2025	561	-

2.2	Биологийн нөхөн сэргээлтийг 300 га-аар нэмэгдүүлнэ.	Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ	га	2020	44.5	2025	345.5	-
2.3	53.8 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авна.	Тусгай хэрэгцээнд байгаа газрын хэмжээ	га	2019	446.2	2025	500	-
2.4	20 Булаг, шанд, гол, горхины урсацыг нөхөн сэргээнэ	Урсацыг нь нөхөн сэргээсэн булаг, шанд, гол, горхины тоо	тоо	2020	4	2025	20	-
2.5	Хот, суурин газрын агаарын чанарын индексийг 6.5-аар бууруулна.	агаарын чанарын индекс	индекс	2020	184	2025	177.5	-
3	1 хүнд ногдох ДНБ-нийг суурь түвшнээс 3 хувиар өсгөнө.	1 хүнд ногдох ДНБ-ний жилийн дүн	Сая.төг	2020	8027.8	2025	8268.6	Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих
3.1	Орон нутгийн орлогыг суурь түвшнээс 28.5 хувиар өсгөнө.	төсвийн орлогын хэмжээ	тэрбум.төг	2020	31.60	2025	40.60	-
3.2	Үйлчилгээний салбарын өсөлтийг тогтвортой хадгална.	Үйлчилгээний салбарын ААН-ийн тоо	тоо	2020	1246	2025	1,328	-
3.3	Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг (нийлүүлэлтээр) 2 хувьд хүргэнэ.	Эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	хувь	2020	0.03	2025	2	-
3.4	Орон нутгийн авто замын сүлжээг 250 км-ээр өргөтгөнө.	Шинээр өргөтгөл, шинэчлэл хийсэн замын урт	км	2020	39.18	2025	289	-
3.5	Интернет хэрэглэгчийн тоог улсын дундаж үзүүлэлтэд хүргэнэ.	Интернэтийн хэрэглэгчийн хувь	хувь	2020	62.8	2025	64.7	-
3.6	Аж үйлдвэрийн салбарын борлуулалтад боловсруулах үйлдвэрийн борлуулалтын эзлэх хувийг 23-д хүргэнэ.	Аж үйлдвэрийн салбарын борлуулалтад боловсруулах үйлдвэрийн борлуулалтын эзлэх хувь	хувь	2020	18.55	2025	23.00	-
3.7	ДНБ-д эзлэх аялал жуулчлалын орлогыг 5 хувьд хүргэнэ.	ДНБ-д эзлэх аялал жуулчлалын салбарын орлогын эзлэх хувь	хувь	2020	3.1	2025	5	-

3.8	1 га аас авах ургацын хэмжээг 15 хувиар өсгөнө.	1 га талбайгаас авах үр тарианы хэмжээ	цн	2020	12.70	2025	15	-	
		1 га талбайгаас авах төмс, хүнсний ногооны хэмжээ	цн	2020	16.20	2025	19	-	
	3.9	Нийт малын тоонд өндөр ашиг шимтэй малын эзлэх хувийг 30.3-д хүргэнэ.	Нийт малын тоонд өндөр ашиг шимтэй малын эзлэх хувь	хувь	2020	23.30	2025	30.30	-
4	Хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.704-д хүргэнэ		Хүний хөгжлийн индекс	индекс	2019	0.696	2025	0.704	Эрүүл амьдралын дадал, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
4.1	СӨБ ын хамран сургалтын цэвэр жинг 83.9%-д хүргэнэ.	Цэвэр жин	хувь	2020	82.8	2025	83.9	-	
4.2	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг 93.0%-д хүргэнэ.	Цэвэр жин	хувь	2020	87.4	2025	93	-	
4.3	ЕБС-ын сургалтын чанарын үзүүлэлтийг 41.7%-д хүргэнэ.	Сурагчдын сурлагын ахиц	хувь	2020	41.2	2025	41.7	-	
	ХАА-н салбараар дээд болон мэргэжлийн боловсролыг орон нутагт эзэмших боломжийг нэмэгдүүлэх	Их дээд сургуульд суралцагчдын нийт дүнд Сэлэнгэ аймагт суралцагчдын эзлэх хувь (зөвхөн ХАА чиглэлээр)	хувь	2020	0	2025	50	-	
		Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагчдын нийт дүнд Сэлэнгэ аймагт суралцагчдын эзлэх хувь (зөвхөн ХАА чиглэлээр)	хувь	2020	a*	2025	a+20	-	
4.4	Нийт иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг 10 пунктээр нэмэгдүүлнэ.	Нийт иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь	хувь	2020	28.0	2025	38.0	-	

4.5	Зонхилон тохиолдох өвчлөлийг 10 пунктээр бууруулна.	Зонхилон тохиолдох өвчлөлийн хувь	хувь	2020	75.8	2025	65.8	-
4.6	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжилд чиглэсэн дэмжлэгийг зорилтот түвшинд хүргэнэ	Гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн эзлэх хувь	хувь	2020	90	2025	95	-
		Залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан залуучуудын эзлэх хувь	хувь	2020	34.5	2025	40	-
		Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулан шийдвэрлэсэн хувь	хувь	2020	95	2025	95	-
4.7	Иргэдийн бие бялдар, чийрэгжилтийн дундаж түвшинг 21.5-д хүргэнэ.	Насанд хүрэгчид/хүүхэд бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тодорхойлох сорилын дундаж оноо	оноо	2019	20.8	2025	21.5	-
4.8	10000 хүнд ногдох соёл урлагийн үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.	Үйлчилгээний тоо	тоо	2021	355	2025	670	-
4.9	Шинэ ажлын байрыг жилд 1000-аар нэмэгдүүлнэ.	Шинэ ажлын байрны тоо	тоо	2020	1105	2025	6105	-
5	Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө. (Засаглалын үнэлгээ= ШБУ*0.5+ИОУ*2.5+ХҮ*2.5)	Засаглалын үнэлгээ	оноо	2021	68.65	2025	78.85	Бүтээлч оролцоо, хариуцлагатай байдлыг сайжруулах
5.1	Захиргааны байгууллагын шийдвэр гаргалтан дахь иргэдийн оролцоог 1.6-аар нэмэгдүүлнэ.	Шийдвэр гаргалтан дахь оролцоо (0-10 оноо)	оноо	2021	5	2025	6.6	-
5.2	Төрийн байгууллагуудын шударга байдлын индексийг 80.5-д хүргэнэ.	Шударга байдлын үнэлгээ	Индекс	2021	76.3	2025	80.5	-


	5.3	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг 1.62-оор өсгөнө	Хэрэглэгчийн үнэлгээний дундаж дүн (0-10 оноо)	Дундаж оноо	2021	7.2	2025	8.84	-
6	Иргэдийн амар тайван, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдлийг бууруулна.		Иргэдийн аюулгүй, амар тайван байдлын мэдрэмжийн үнэлгээ	хувь	2022	a*	2025	a+0.5	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан сайжруулах
	6.1	10000 хүнд ногдох гэмт хэргийн гаралтын тоо 7-оор бууруулна.	10000 хүнд ногдох гэмт хэргийн гаралтын тоо	тоо	2021	52	2025	45	-
			Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн хэмжээ	хувь	2021	52.2	2025	65	-
	6.2	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 1.2 пунктээр сайжруулна.	Хэрэгжилтийн хувь	хувь	2021	95.5	2025	96.7	-
	6.3	Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нэмэгдүүлнэ.	Гамшгийн улмаас учирсан хохирлын хэмжээ	төгрөг	2021	383.0 сая	2025	306.4 сая	-
	6.4	Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилтын хэрэгжилтийг бүрэн хангана.	Хэрэгжилтийн хувь	хувь	2021	91.5	2025	100	-

Тайлбар: a*-төлөвлөгөө хэрэгжиж эхлэх үед иргэдийн дунд судалгааг хийж суурь түвшинг тодорхойлох.

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА

Аймгийн стратегийн зорилго, зорилт ба хариуцах байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог дараах байдлаар хангаж ажиллана. Тухайлбал, аймгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх суурь нөхцөл нь “Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө” гэсэн 5-р стратегийн зорилго байх болно. Өөрөөр хэлбэл, аймгийн стратегийн зорилгуудын биелэлтийг хангахад аймгийн засаглалын чадавхыг бэхжүүлэхэд нэн тэргүүнд анхаарах бөгөөд энэ нь бусад зорилгуудын биелэлтийг хангахад манлайлах үүрэгтэй байна. Бүхэлдээ аймгийн стратегийн зорилгууд нь харилцан уялдаатай, бие биенээсээ хамааралтай байна.

Зураг 1. Сэлэнгэ аймгийн стратегийн зорилгуудын уялдаа



Мөн аймгийн Засаг даргын харьяа байгууллага, нэгж тус бүр өөрсдийн үндсэн үүргээс гадна аймгийн стратегийн зорилго, байгууллага, нэгж хоорондын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах туслах үүргийг мөн гүйцэтгэнэ. Тухайлбал,

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Онцгой Байдлын Штаб нь “Ковидоос шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг давна” гэсэн 1-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
2. Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь “Байгаль орчны эмзэг байдлын индексийг зорилтот түвшинд хүргэнэ” гэсэн 2-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
3. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс нь “1 хүнд ногдох ДНБ-нийг суурь түвшнээс 3 хувиар өсгөнө” гэсэн 3-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.

түвшнээс 3 хувиар өсгөнө” гэсэн 3-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.

4. Боловсрол шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир спортын газар нь “Хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.704-д хүргэнэ” гэсэн 4-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
5. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь “Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө” гэсэн 5-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.
6. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар нь “Иргэдийн амар тайван, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдлийг бууруулна” гэсэн 6-р стратегийн зорилгыг удирдан манлайлж ажиллана.

Стратегийн зорилгыг манлайлагч байгууллага, нэгжүүд нь үйл ажиллагааны хувьд харилцан уялдаатай ажиллах нь аймгийн стратегийн зорилго, зорилгуудын биелэлтийг хангах гол үндэс болно. Мөн стратегийн зорилгыг хэрэгжүүлэхэд манлайлах үүрэг гүйцэтгэх эдгээр байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааг бусад холбогдох байгууллага, нэгжүүд нь дэмжиж, нягт уялдаатай ажиллана. Тухайлбал, дараах хэсэгт аймгийн стратегийн зорилт ба түүнийг хэрэгжүүлэгч байгууллага, нэгжүүдийн уялдааг дэлгэрэнгүй хэлбэрээр харуулсан болно.

Хүснэгт 7. Стратегийн зорилго, зорилт ба хариуцах байгууллага, нэгж

Стратегийн зорилго, зорилт	Зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэгч байгууллага		
		Үндсэн хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	
Стратегийн зорилго 1. Ковидоос шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг давах		АЗДТГ, Аймгийн онцгой байдлын штаб		
1.1	Ковидын улмаас ААН-д учирсан доголдолыг бүрэн арилгана	1.1.1 Аймгийн хэмжээнд "Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлсэн ковидын нөлөө" сэдэвт судалгааг зохион байгуулж үзүүлсэн нөлөө, үр дагаврыг тодорхойлох	АЗДТГ, СТСХ	Сумдын ЗДТГ, ТХ, СХ
	1.1.2. "Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлсэн ковидын нөлөө" сэдэвт судалгааны үр дүнд үндэслэн аж ахуйн нэгжийг бүлэглэж, бүлэг тус бүрийн онцлогоос хамааруулан үйл ажиллагааг нь сэргээхэд чиглэсэн төлөвлөгөөг боловруулан, хэрэгжүүлэх	АЗДТГ, СТСХ	АЗДТГ, АСХ, ХАУТ	
	1.1.3. ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх	ХХҮГ	Аймаг, сумын ЗДТГ	
1.2	ЕБС-ийн сурагчдын хичээлийн хоцрогдлыг 100 хувь арилгана.	1.2.1 Сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын түвшин тогтоох, хоцрогдлын шалтгааныг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулах	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
	1.2.2 Түвшин тогтоох, шалтгаан илрүүлэх судалгааны (1.2.1-д заасан) үр дүнд үндэслэсэн хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө, удирдамжийг боловруулж, хэрэгжүүлэх	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд	
	1.2.3. Онцгой нөхцөлд сурагчдын сурч хөгжих боломжийг тасралтгүй хангах зорилгоор теле, цахим хичээлийг чанартай зохион байгуулах байнгын бэлэн байдлыг хангах	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд	

1.3	Ковидоор өвчилсөн иргэдийг бүрэн эмчилнэ.	1.3.1 Ковидын тархалт, өвчлөлийн зэргээс (хүнд, хүндэвтэр, хөнгөн) хамааруулан эмнэлгийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй, үр ашигтай үзүүлэх удирдамж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, ЭМДХ
		1.3.2 Урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэж буй вакцинжуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, ЭМДХ
		1.3.3 Халдварт өвчний тархалт ихтэй үед өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, хувь хүн өөрийгөө хамгаалахад чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, ухуулан таниулах ажлыг зорилтот бүлэг бүрт тохирсон арга зүйгээр зохион байгуулах	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, ЭМДХ
		1.3.4 Ковидоор өвчлөөд эдгэрсэн иргэдэд зориулсан цаашид хэрэгжүүлэх дэглэм, нөхөн сэргээх болон сэтгэл зүйн эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг хувийн хэвшил, ТББ, сайн дурынханд түшиглэн зохион байгуулах	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ, ЭМДХ, хувийн хэвшлийн болон ТББ байгууллага
Стратегийн зорилго 2. Байгаль орчны эмзэг байдлын индексийг зорилтот түвшинд хүргэнэ.			БОАЖГ	
2.1	Техникийн нөхөн сэргээлтийг 450 га-аар нэмэгдүүлнэ.	2.1.1 Ашигт малтмалын олборлолтын улмаас эвдрэлд орсон газруудад техникийн нөхөн сэргээлт хийх	БОАЖГ	Сумдын ЗДТГ, АЗДТГ, МХГ, ЦГ
		2.1.2 Уул уурхайн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх /ҮЧ-6.1.2/	БОАЖГ	Сумдын ЗДТГ, АЗДТГ, ИНБ
2.2	Биологийн нөхөн сэргээлтийг 300 га-аар нэмэгдүүлнэ.	2.2.1 Ашигт малтмалын олборлолтын улмаас эвдрэлд орсон газруудад биологийн нөхөн сэргээлт хийх	БОАЖГ	Сумдын ЗДТГ, АЗДТГ, МХГ, ЦГ, ИНБ
		2.2.2 Ус хөрсийг хамгаалах, цөлжилт, бэлчээрийн доройтлоос сэргийлэх ойн зурвас бүхий талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Сумдын ЗДТГ	БОАЖГ, ХХААГ
		2.2.3 Ой хээрийн түймрээс хамгаалах шороон зурвасыг сэргээх ажлыг зохион байгуулах	БОАЖГ	Хилийн цэргийн 0243-р ангийн захирагч
		2.2.4 Ойн агропарк байгуулах	БОАЖГ	Сумдын ЗДТГ
		2.2.5 Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур тарималжуулах ажлыг хийх	БОАЖГ	Сумдын ЗДТГ, ААНБ
2.3	53.8 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авна.	2.3.1 Түүхэн болон байгаль экологи, эдийн засгийн хувьд ач холбогдолтой газар нутгийг тусгай хамгаалалтад авах ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ	БОАЖГ, АЗДТГ, ГХБХБГ
		2.3.2 Аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээллийн ил тод байдлыг хангах	ГХБХБГ	Сумдын ЗДТГ
2.4	20 Булаг, шанд, гол, горхины урсацыг нөхөн сэргээнэ	2.4.1 Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн дэглэмийг сайжруулах, усны бохирдол, хомсдолыг бууруулах /ҮЧ-6.2.1/	Сумдын ЗДТГ	БОАЖГ
		2.4.2 Жил бүр таваас доошгүй булаг, шандыг хашиж хамгаалах	Сумдын ЗДТГ	БОАЖГ, ААНБ, ИНБ
		2.4.3 Гол горхи, булаг шандын урсацыг нөхөн сэргээх иргэдийн санал, санаачилгыг дэмжих, шаардлагатай арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ	БОАЖГ, ИНБ

2.5	Хот, суурин газрын агаарын чанарын индексийг 6.5-аар бууруулна.	2.5.1 Агаар орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургах	БОАЖГ, УЦУОШГ	Аймаг, сумдын ЗДТГ
		2.5.2 "Ногоон сум" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ	БОАЖГ, АЗДТГ
		2.5.3 Био жорлон арга хэмжээг зохион байгуулах, хөрсний бохирдлыг бууруулах	Сумдын ЗДТГ	БОАЖГ, АЗДТГ
		2.5.4 Томоохон төв суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлын шинжилгээ хийж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, УЦУОШГ	БОАЖГ, АЗДТГ
		2.5.5 "Сэлэнгэ-Энерго" ОНӨААТҮГ, "Цэнгэг-Ус" ОНӨААТҮГ тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх	Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ, "Цэнгэг ус" ОНӨААТҮГ	АЗДТГ
		2.5.6 ЕБС-ын сурагчдад байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадал, мэдлэг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	БОАЖГ, БШУГ	ЕБС, Төсөл хөтөлбөрийн газрууд
Стратегийн зорилго 3. Нэг хүнд ногдох ДНБ-нийг суурь түвшнээс 3 хувиар өсгөнө.			АЗДТГ, ХХААГ, Татварын хэлтэс	
3.1	Орон нутгийн орлогыг суурь түвшнээс 28.5 хувиар өсгөнө.	3.1.1 Татвар төлөгчдийн бүртгэлийн сайжруулах, татварын суурийг нэмэгдүүлэх	Аймгийн Татварын хэлтэс	Аймаг, сумын ЗДТГ, ААНБ
3.2	Үйлчилгээний салбарын өсөлтийг тогтвортой хадгална.	3.2.1 Ахуйн үйлчилгээг цогцолборыг хөгжүүлэх	АЗДТГ	Сумдын ЗДТГ, ХХААГ, СХЗГ, МХГ, ААНБ
		3.2.2 Экспортын бараа, бүтээгдэхүүний Outlet төв бий болгох /Алтанбулагт/	АЗДТГ	Сумдын ЗДТГ, ХХААГ, СХЗГ, МХГ, ААНБ
		3.2.3 Худалдаа үйлчилгээний орчин нөхцлийн стандарт хэрэгжилтийг сайжруулах, үйлчилгээний шинэ соёлыг төлөвшүүлэх	ХХААГ, Сумдын ЗДТГ	АЗДТГ, СХЗГ, МХГ
		3.2.4 МСҮТ-д худалдаа, үйлчилгээний боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх	БШУГ, МСҮТ	АЗДТГ
		3.2.5 Тээвэр ложистикийн төв байгуулах/ҮЧ-4.1.4/	Гаалийн газар, Сумдын ЗДТГ	Автотээврийн газар, ААНБ
3.3	Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг (нийлүүлэлтийг, суурилагдсан хүчин чадал) 2 хувьд хүргэнэ.	3.3.1 Шинэ сууршлын бүсийг сэргээгдэх эрчим хүчээр хангах	Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.3.2 Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх	Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.3.3 Аймгийн төвд 50 мвт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих	АЗДТГ	ГХБХБГ
		3.3.4 Ерөө голын түшиглэн 10мвт чадалтай бага оврын усан цахилгаан станц барих	Сумын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
3.4	Орон нутгийн авто замын сүлжээг 250 км-ээр өргөтгөнө.	3.4.1 Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг чиглэлийн 120.8 км авто замын ажлыг барьж байгуулах	Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.4.2 Хүдэр сумын дотор 10 км, Орхонтуул сумын 60 км авто замын ажлыг барьж байгуулах	Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.4.3 Сүхбаатар сумын автозамыг өргөтгөж, гэрлэн дохиог шинээр байршуулах	Сумын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ, ЦГ
		3.4.4 Ерөө-Бугант чиглэлийн хатуу хучилттай 74 км авто замын ажлыг барьж байгуулах	Сумын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.4.5 Аймгийн хэмжээнд замын тэмдэг, тэмдэглэгээг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх	Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.4.6 Стандартын шаардлагад нийцсэн авто вокзалыг барьж ашиглалтанд оруулах	Сумын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ

3.5	Интернет хэрэглэгчийн тоог улсын дундаж үзүүлэлтэд хүргэнэ.	3.5.1 Сумдын интернет холболтын хүчин чадлыг нэмэгдүүлэх	МЦХК, Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
		3.5.2 Ерөө сумын Бугант тосгоны төрийн байгууллагуудыг шилэн кабель холбож, хүн амыг өндөр хурдны интернетийн үйлчилгээгээр хангах /ҮЧ-5.2/	Сумын ЗДТГ, МЦХК	АЗДТГ, ГХБХБГ
		3.5.3.Мандал сумын Түнхэл тосгоныг шилэн кабельд холбох ажлыг үе шаттайгаар хийж, Сүхбаатар сумын төвийн шилэн кабелийн сүлжээнүүдийг худаг сувагчлалд оруулах	МЦХК, Сумдын ЗДТГ	АЗДТГ, ГХБХБГ
3.6	Аж үйлдвэрийн салбарын борлуулалтад боловсруулах үйлдвэрийн борлуулалтын эзлэх хувийг 23 хүргэнэ.	3.6.1 "Сум бүрт нэг үйлдвэрлэл, үйлчилгээ" арга хэмжээг төр хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.6.2 Аймгийн хэмжээний жижиг дунд үйлдвэрлэгчдийн брэнд бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх, нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ
		3.6.3 Баялаг бүтээгч иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих аян өрнүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.6.4 "Сэлэнгийн брэнд"-ийн нэр төрлийг нэмэгдүүлэх, экспортын дэмжлэг үзүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.6.5 Хушаат суманд "Цардуулын үйлдвэр" байгуулах	Сумын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.6.6 Барилгын материалын хийц, эдлэл үйлдвэрлэх санал, санаачилгыг дэмжих	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.6.7 Био тэжээл, био бордоо, хадлан тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.6.8 Нэхээсгүй эдлэл болон цэмбэний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлж энэ чиглэлийн үйлдвэрлэлийн гол төв болох	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.6.9 Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйлдвэр байгуулах	Сумдын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ, ААНБ
		3.6.10 Аймгийн нутаг дэвсгэр, сумдын онцлог, давуу талд түшиглэн боловсруулах үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх (Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад хүнсний ногоо, сүү,сүүн бүтээгдэхүүний, Хүдэр, Түшиг сумдад жимс, жимсгэний, Хүдэр сум, Түнхэл, Бугант тосгонд мод боловсруулах)	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.6.11 Хөнгөн үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, дэмжих зорилгоор “Бизнес хөгжил (сургалт, судалгаа, зөвлөгөө, мэдээлэл)”-ийн төв байгуулах.	ХХААГ	Аймаг, сумдын ЗДТГ
		3.6.12 “Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлого” боловсруулж, хэрэгжүүлэх	АЗДТГ	БОАЖГ, аймгийн ИТХ
3.7	ДНБ-д эзлэх аялал жуулчлалын орлогыг 5 хувьд хүргэнэ.	3.7.1 "Сайханы хөтөл"-д олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын цогцолбор байгуулах	АЗДТГ	Сумын ЗДТГ, БОАЖГ, ААНБ
		3.7.2 Нутгийн иргэдийн аж байдалд (Эрчимжсэн мал аж ахуйн ферм, газар тариалангийн үйлдвэрлэл, зөгийн аж ахуй, модон эдлэлийн үйлдвэр, тужийн нарс мод үржүүлэг зэргийг бодитоор хараад оролцох боломжийг хангасан) тулгуурласан аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	БОАЖГ	Аймаг, сумдын ЗДТГ

		3.7.3 Аймгийн аялал жуулчлалын цогц мэдээллийг агуулсан цахим хуудас, аппликейшин хөгжүүлэх	БОАЖГ	Аймаг, сумдын ЗДТГ
		3.7.4 Аялал жуулчлалын маршрут болон олон улсын чанартай автозамын дагуух түр буудаллах цэгүүдийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулах /ҮЧ-8.2.2/	Сумдын ЗДТГ	БОАЖГ, АЗДТГ
		3.7.5 Агаарын хөлөг хөөрч буух зурвас байгуулж, нислэг үйлдэх хэвийн үйл ажиллагааг хангах	АЗДТГ	Сумын ЗДТГ
		3.7.6 Аялагч, жуулчлалд зориулсан түүх, соёл, урлагийн арга хэмжээний тоог нэмэгдүүлэх	Сумдын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ, Соёлын газар,
3.8	1 га-аас авах ургацын хэмжээг 15 хувиар өсгөнө.	3.8.1 Атрын 4-р аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ
		3.8.2 Ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.8.3 Усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.8.4 Агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах санаачилгыг дэмжин хамтран ажиллах	ХХААГ	Аймаг, сумдын ЗДТГ, ААНБ
		3.8.5 Хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжих	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.8.6 Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ, иргэн
		3.8.7 Таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг бүс нутгийн онцлогтой уялдуулан хөгжүүлэх, нутагшсан сортын дээд үржүүлгийн үрийн хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.8.8 “Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” төсөл хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
3.9	Нийт малын тоонд өндөр ашиг шимтэй малын эзлэх хувийг 30.3-д хүргэнэ.	3.9.1 "Эрчимжсэн үхрийн аж ахуй" төсөл боловсруулан хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.9.2 ХАА-н даатгалын тогтолцоог сайжруулах/ҮЧ-8.3.2/	НДХ	Аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ
		3.9.3 Малын гарал үүслийн гэрчилгээ баталгаажуулалтын нэгдсэн цахим систем нэвтрүүлэх /ҮЧ-8.3.8/	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ
		3.9.4 "Сэлэнгэ мах" төсөл хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.9.5 "Сэлэнгэ сүү" төсөл хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.9.6 "Нарийн нарийвтар ноост хонь" төсөл хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
		3.9.7 Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Сумдын ЗДТГ, МЭГ	АЗДТГ, ААНБ
		3.9.8 Мал эмнэлгийн лабораторийн техник, технологийн хүчин чадал, боловсон хүчнийг чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ, МЭГ	АЗДТГ

		3.9.9 Тахилт, Хөшөөтийн даваанд Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэл, хяналт шалгалтын нэгдсэн цэг байгуулах	Сумдын ЗДТГ, МЭГ	АЗДТГ
		3.9.10 Мал амьтны өвчний танадалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын ISO 17025 стандартыг нэвтрүүлэх	Сумдын ЗДТГ, МЭГ	АЗДТГ
		3.9.10 Эрчимсэн аж ахуйн хөгжлийн цогцолбор төв байгуулах (Үүнд: 1.Эрчимжсэн аж ахуйд ажиллах боловсон хүчин бэлтгэх, 2.Эрчимжсэн аж ахуйн судалгаа, шинжилгээ, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх, 3.Өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, хээлтүүлэгчээр хангах арга хэмжээг хэрэгжүүлэх)	Сумдын ЗДТГ, ХХААГ	АЗДТГ, ААНБ
Стратегийн зорилго 4. Хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.704-д хүргэнэ			БШУГ,ЭМГ, СУГ, ГБХЗХГ, БТСГ, ХХҮГ	
4.1	СӨБ ын хамран сургалтын цэвэр жинг 83.9%-д хүргэнэ.	4.1.1 Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны хүүхдийн ялгаатай нөхцөл, хэрэгцээнд тохируулсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	БШУГ	АЗДТГ, цэцэрлэгүүд
		4.1.2 Таван настай хүүхдийг цэцэрлэгт 100% хамруулах	БШУГ	АЗДТГ, цэцэрлэгүүд
		4.1.3 СӨБ-ийн байгууллагын техник хэрэгсэл, орчин нөхцлийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	БШУГ	АЗДТГ, цэцэрлэгүүд
		4.1.4 СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн биеийн болон сэтгэлийн эрүүл мэнд, хөгжил, төлөвшилд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх (хоол хүнс, дасгал хөдөлгөөн, сэтгэл зүй гэх мэтийг агуулсан)	БШУГ	АЗДТГ, цэцэрлэгүүд
4.2	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг 93.0%-д хүргэнэ.	4.2.1 Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн сургалтын орчинг сайжруулах	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.2.2 Шинээр өргөтгөл барьж, сургуулийн сургалтын орчныг сайжруулж, анги танхимын тоог нэмэгдүүлэх	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.2.3 Зарим сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, дотуур байранд их засвар хийх	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
4.3	ЕБС-ын сургалтын чанарын үзүүлэлтийг 41.7%-д хүргэнэ.	4.3.1 Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.3.2 "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.3.3 Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж, төлөвшүүлэхэд чиглэсэн сургууль, багш, иргэн, аж ахуйн нэгжийн санал, санаачилгыг дэмжиж ажиллах	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд, ИНБ
		4.3.3 "Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж" арга хэмжээг хэрэгжүүлэх	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.3.4 Сурагчдын биеийн болон сэтгэлийн эрүүл мэнд, хөгжил, төлөвшилд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх (хоол хүнс, дасгал хөдөлгөөн, сэтгэл зүй гэх мэтийг агуулсан)	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.3.5 Гадаад, дотоодын боловсролын байгууллагуудтай олон талт харилцааг хөгжүүлэх	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
		4.3.6 Эцэг эх, сурагч, сургууль багшийн бүтээлч хамтын ажиллагаа, санал санаачилгыг дэмжих	БШУГ	АЗДТГ, ЕБС-иуд
4.4	ХАА-н салбараар дээд болон	4.4.1 ХААИС-ийн салбар сургууль байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	БШУГ	АЗДТГ

	мэргэжлийн боловсролыг орон нутагт эзэмших боломжийг нэмэгдүүлэх	4.4.2 Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг хөгжүүлэх	БШУГ	АЗДТГ
4.5	Нийт иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг 10 пунктээр нэмэгдүүлнэ.	4.5.1 Иргэд, хүүхэд, аж ахуй нэгж байгууллагуудын ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах	ЭМГ, ААНБ	Сумын ЗДТГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
		4.5.2 Иргэд болон аж ахуй нэгж байгууллагуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах	ЭМГ, ААНБ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
		4.5.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи ашиглах	ЭМГ, ААНБ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
4.5	Зонхилон тохиолдох өвчлөлийг 10 пунктээр бууруулна.	4.5.1 Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг оношлогоо, шинжилгээг зохион байгуулах	Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
		4.5.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг сайжруулах	Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
		4.5.3 Эмч, эмнэлгийн ажилтныг гадаад, дотоодод туршлага судлуулах, давтан сургах арга хэмжээг зохион байгуулах	Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн газар
4.6	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжилд чиглэсэн дэмжлэгийг зорилтот түвшинд хүргэнэ	4.6.1 Хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах	ГБХЗХГ	Сумдын Хамтарсан баг
		4.6.2 Эцэг эхийн зөвлөлийн тэргүүн туршлага судлах, сурталчлах	ГБХЗХГ	Сумдын Хамтарсан баг
		4.6.3 Иргэдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээллээр хангах	ГБХЗХГ	АЗДТГ, Цагдаагийн газар
		4.6.4 Түр хамгаалах байрны үйлчилгээг үзүүлэх	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ
		4.6.5 Хүүхэд, залуучуудад зориулсан гэр бүл төлөвлөлтийн сургалт, сурталчилгааг зохион байгуулах	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ, ТББ
		4.6.6 Залуучууд хөгжлийн төв, залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ, ТББ
		4.6.7 Залуучуудын хөгжлийг дэмжих сургалт, дадлагажуулалтыг үе шаттай зохион байгуулах	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ
		4.6.8 Хүүхдийн тусламжийн 108 утас ажиллуулах, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ
		4.6.9 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээ үзүүлэх	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ, Хамтарсан баг
		4.6.10 Зорилтот бүлгийн онцлогт тохирсон хүүхэд хамгаалал, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ
		4.6.11 Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ
		4.6.12 Хүүхдийн болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ, ТББ
		4.6.13 ААН, байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхэд, залуучуудын амьдрах орчин, боловсрол, гэр бүлд оруулах дэмжлэгийг нэмэгдүүлэх	ГБХЗХГ	Сумдын ЗДТГ

4.7	Иргэдийн бие бялдар, чийрэгжилтийн дундаж түвшинг 21.5-д хүргэнэ.	4.7.1 Арга зүйчгүй сумдад орон тооны арга зүйчийг ажиллуулах	Сумдын ЗДТГ	БТСГ
		4.7.2 Хүн амын бие бялдарын түвшин тогтоох сорилыг стандарт үзүүлэлтээр жил бүр 4, 10 сард тогтмол авч хэвшүүлэн судалгааг хийж, үр дүнг нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, үнэлэхэд ашиглах	БТСГ	Сумдын ЗДТГ, спорт цогцолбор
		4.7.3 Албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, ажилчдын бие бялдарыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллах	БТСГ	Албан байгууллага, аж ахуйн нэгж
		4.7.4 Усан спортоор хичээллэх арга зүйн сургалт зохион байгуулах	Усан спорт сургалтын төв	БТСГ
		4.7.5 Нийтийг хамарсан биеийн тамир спортын уралдаан тэмцээн, арга хэмжээг зохион байгуулах	БТСГ	АЗДТГ, Сумын ЗДТГ
		4.7.6 Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулах	БТСГ	АЗДТГ
		4.7.7 Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн өөрөө суралцах контент хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх	БТСГ	АЗДТГ, Сумын ЗДТГ
4.8	10000 хүнд ногдох соёл урлагийн үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ	4.8.1 Аймгийн соёл, урлагийг хөгжүүлэх бодлого, нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх	СУГ	АЗДТГ, СУГ
		4.8.2 “Соёлын аялал жуулчлал” арга хэмжээг зохион байгуулах	СУГ	АЗДТГ, СУГ
		4.8.3 “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг зохион байгуулах	СУГ	АЗДТГ, СУГ
		4.8.4 “Хувьсгалын өлгий” үзэсгэлэн зохион байгуулах	СУГ	Сумдын ЗДТГ, Соёлын байгууллагууд
		4.8.5 Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, зөвлөгөөн зохион байгуулах	СУГ	Аймаг, сумдын ЗДТГ, Соёлын байгууллагууд
		4.8.6 Хүүхдэд зориулсан уран бүтээл үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэх	СУГ	Сумдын ЗДТГ, Соёлын байгууллагууд
		4.8.8 Соёл, урлагийн үйлчилгээнд дэвшилтэд технологи ашиглах	СУГ	Сумдын ЗДТГ, Соёлын байгууллагууд
4.9	Шинэ ажлын байрыг жилд 1000-аар нэмэгдүүлнэ.	4.9.1 Ажил хөдөлмөр эрхлээгүй залуучуудыг гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх анхан шатны сургалт зохион байгуулах	ХХҮГ	МСҮТ
		4.9.2 Гарааны бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	ХХҮГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ
		4.9.3 Тусгай хэрэгцээт иргэдийн хөдөлмөрлөх нөхцөл, боломжийг бүрдүүлэх	ХХҮГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ
		4.9.4 Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	НДХ	Сумдын ЗДТГ мэргэжилтнүүд
		4.9.5 Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчийг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх	ХХҮГ	Сумдын ЗДТГ, аж ахуйн нэгж байгууллага

		4.9.6 Аймгийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлаар сэдэвчилсэн судалгааг хийж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Сумдын ЗДТГ	ХХҮГ
Стратегийн зорилго 5. Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө.			Аймгийн ЗДТГ	
5.1	Захиргааны байгууллагын шийдвэр гаргалтан дахь иргэдийн оролцоог 1.6-аар нэмэгдүүлнэ.	5.1.1 Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх "Таныг сонсьё" арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлэх	Төр төсвийн бүх шатны байгууллагууд	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд
		5.1.2 Аймгийн бодлогын баримт бичгийн төсөлд иргэдийн саналыг авч тусгах ажиллагааг цахим болон бусад хэлбэрээр зохион байгуулах тогтолцоог бий болгох	АЗДТГ	Сумдын ЗДТГ, агентлагууд
		5.1.3 Иргэн, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагын бүтээлч хамтын ажиллагааг дэмжих	АЗДТГ, иргэний нийгмийн байгууллагууд	Сумдын ЗДТГ
5.2	Төрийн байгууллагуудын шударга байдлын индексийг 80.5-д хүргэнэ.	5.2.1 "Шударга удирдагч-Шударга төрийн албан хаагч" аяныг жил бүр өрнүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сайн туршлагаудыг нутагшуулж, хэрэгжүүлэх	АЗДТГ	Сумын ЗДТГ, Агентлагууд
		5.2.2 Тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг цахимжуулах ажлыг нэмэгдүүлэх	АЗДТГ	Сумын ЗДТГ, Агентлагууд
		5.2.3 "Авлигын эрсдлийн үнэлгээ"-г аймгийн хэмжээнд хийж эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	АЗДТГ	Төр, төсвийн байгууллагууд
		5.2.4 Төрийн байгууллагын мэдээллийг ил тод нээлттэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	АЗДТГ	Төр, төсвийн байгууллагууд
		5.2.5 Төрийн байгууллагын нээлттэй мэдээллийг иргэдэд хүргэх сувгийн тоог нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагаас төрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийх тогтолцоог бий болгох	Төр, төсвийн байгууллагууд	Хэвлэл мэдээллийн байгууллагууд
5.3	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээг 1.62-оор өсгөнө	5.3.1 Аймгийн иргэдийн амьдралын чанарыг үнэлэх судалгааг хоёр жил тутамд хийж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	АЗДТГ	Иргэний нийгмийн байгууллага
		5.3.2 Төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг байгууллага тус бүрээр хийж, үр дүнг гүйцэтгэлийг төлөвлөх, үнэлэхэд ашиглах	Төр, төсвийн байгууллагууд	Сумдын ЗДТГ, агентлагууд, Иргэний нийгмийн байгууллага
		5.3.3 Төрийн албан хаагчдын томилгоо, сонгон шалгаруулалтыг хуульд бүрэн нийцүүлэх	ТАЗ-ийн Сэлэнгэ салбар	Төр, төсвийн байгууллагууд
		5.3.4 Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх	ТАЗ-ийн Сэлэнгэ салбар	Аймаг, сумын ЗДТГ, агентлагууд
		5.3.6 Аймгийн хэмжээний бүртгэл, статистикийн үйл ажиллагааг чанаржуулж, бодлого боловсруулалт, шийдвэр гаргалт, хэрэгжилттэй нягт холбоход чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Статистикийн хэлтэс	Бусад байгууллага
Стратегийн зорилго 6. Иргэдийн амар тайван, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдлийг бууруулна.			АЗДТГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар	
6.1	10000 хүнд ногдох гэмт хэргийн	6.1.1 Гудамж, зам, талбай, олон нийтийн газрын камерын тоог нэмэгдүүлэх	АЗДТГ	ЦГ, ГХУСАЗСЗ

	гаралтын тоо 7-оор бууруулна.	6.1.2 Гэмт хэргийн эрсдлийн үнэлгээ хийж эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх	АЗДТГ	ЦГ, ГХУСАЗСЗ
		6.1.3 Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг жил бүр тусгайлан төлөвлөж хэрэгжүүлэх	АЗДТГ	ЦГ, ГХУСАЗСЗ
		6.1.4 Хууль хяналтын байгууллагуудын хоорондын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах	АЗДТГ	Хууль хяналтын байгууллагууд
		6.1.5 Хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо хэрхэн нөхөн төлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх	АЗДТГ	ЦГ, ГХУСАЗСЗ
		6.1.6 Байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу үнэлэх ажлыг журмын дагуу хийлгүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	АЗДТГ	ЦГ
6.2	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 1.2 пунктээр сайжруулна.	6.2.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон Засаг даргын харьяа агентлагуудаас гаргасан эрх зүйн баримт бичгийн нэгдсэн цахим сан бий болгож иргэд олон нийгэд боломжит бүх хэлбэрээр сурталчлах	АЗДТГ	Сумын ЗДТГ
		6.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт, хэрэгжилттэй уялдуулах	АЗДТГ	Сумын ЗДТГ
6.3	Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нэмэгдүүлнэ.	6.3.1 Сум бүрт зарлан мэдээллийн дуут дохиоллын цамхаг суурилуулах, дотоод зарлан мэдээллийн дэд тогтолцоо байгуулах	Онцгой байдлын газар	сумдын ЗДТГ
		6.3.2 Гамшигт үзэгдлийн эрсдэл тодорхойлж эрсдлээс хамаарсан арга хэмжээ авдаг тогтолцоо бүрдүүлэх	Онцгой байдлын газар	сумдын ЗДТГ
		6.3.3 Онцгой байдлын албаны техникийн болон тусгай хэрэгслийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх	АЗДТГ, Онцгой байдлын газар	-
6.4	Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилтын хэрэгжилтийг бүрэн хангана.	6.4.1 “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийг хангахад чиглэсэн сургалт, дадлагыг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын нөөцийг түшиглэн зохион байгуулж хэрэгжилтийг хангах	АЗДТГ	Сумдын ЗДТГ, Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд
		6.4.2 Цэргийн насны залуучуудын хугацаат цэргийн алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах	АЗДТГ	Сумдын ЗДТГ, Хилийн 0101, 0243 -р анги
		6.4.3 “Эрүүл иргэн – Энхийн манаа” сэдвийн хүрээнд идэрчүүд, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах	АЗДТГ, ЭМГ	Сумдын ЗДТГ, сумдын Эрүүл мэндийн төвүүд
		6.4.4 Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг зохион байгуулах	АЗДТГ, БШУГ	Сумдын ЗДТГ, сумын ЕБС-иуд
		6.4.5 Цэргийн штабын “Сургалтын төв”-ийг байгуулах	АЗДТГ	Сумдын ЗДТГ
		6.4.6 Улсын хил хамгаалалт, хилийн аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг шинэчилж, хил хамгаалах албыг бэхжүүлэх	АЗДТГ	Хилийн сумдын ЗДТГ, Хилийн 0101, 0243-р анги

ЕС. СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ
(2022-2025 он)



БИДНИЙ УРИА: БҮТЭЭЛЧ ОРОЛЦОО – ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

АЛСЫН ХАРАА	Эрчимжсэн хөдөө аж ахуйд суурилсан, байгальд ээлтэй үйлдвэрлэгч аймаг болно.
ЭРХЭМ ЗОРИЛГО	Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэн эдийн засгаа тэтгэж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах.
ҮНЭТ ЗҮЙЛ	Хууль, дээдлэх, ёс зүй, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, мэдлэг инновацийг эрхэмлэх, бүтээлч оролцоо, хамтын ажиллагааг хангах.



ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	Ковид	Ногоон хөгжил	Эдийн засаг	Хүний хөгжил	Засаглал	Аюулгүй нийгэм
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	Ковидоос шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг давна.	Байгаль орчны эмзэг байдлын индексийг зорилтот түвшинд хүргэнэ.	1 хүнд ногдох ДНБ-ийг суурь түвшнээс 3 хувиар өсгөнө.	Хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.704-д хүргэнэ.	Засаглалын үнэлгээг суурь түвшнээс 10 пунктээр өсгөнө.	Иргэдийн амар тайван, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдлийг бууруулна.
СТРАТЕГИ	Зорилтот бүлгийн шаардлагад нийцсэн дэмжлэг үзүүлэх	Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангасан зохистой хэрэглээг дэмжих	Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих	Эрүүл амьдралын дадал, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Бүтээлч оролцоо, хариуцлагатай байдлыг сайжруулах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан сайжруулах

Мандат

- Хүн амд нийгэм, соёлын болон нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх
- Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Хүнсний аюулгүй байдлыг хангаж, ХАА-ыг хөгжүүлэх
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв санхүү, статистикийн бодлого хэрэгжүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах
- Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх
- Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдлыг хангах

**ХАВСРАЛТ 1. СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2022-2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХАВСРАЛТ 2. СЭЛЭНГЭ АЙМГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ